ХАВСРАЛТ №2

ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР, АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

/“.....” болон “.....”-иудын түншлэлийн хооронд 2025 оны дугаар сарын -ны өдөр байгуулав./

ГАРЧИГ

1. ГЭРЭЭНИЙ ҮНЭ 3
2. УРЬДЧИЛГАА ТӨЛБӨР 5
3. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ 5
4. ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ТОХИРУУЛГА 5
5. ЯВЦ ДУНДЫН ТӨЛБӨР 5
6. АЖИЛ 6
7. БАРАА МАТЕРИАЛ – БЭЛТГЭЛ АЖИЛ 6
8. АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ - ДЭЛГЭРЭНГҮЙ 7

1. ГЭРЭЭНИЙ ҮНЭ

1.1. Энэхүү Гэрээний нийт үнийг Захиалагчийн боловсруулж, магадлуулсан “Нэгдүгээр тойрог зам”-ын техник эдийн засгийн үндэслэл (цаашид “ТЭЗҮ” гэх)-ийг эх сурвалж болгон нийт үнэд үндэслэн /LUMP SUM/ тогтоосныг нэгтгэн харуулбал:

Хүснэгт 1.1 Гэрээний нийт үнэ

№	Зардлын нэр	Бүгд өртөг /төгрөг/
1	Гүйцэтгэгчийн гэрээт ажлын дүн	**2,731,964,228,903.65**
2	Захиалагчийн хяналтын зардал	**24,767,772,310.15**
	Бүгд өртөг	**2,756,741,263,209.36**

Тайлбар: Захиалагчаас Гүйцэтгэгчид төлбөл зохих нийт дүн нь доорх дүнгээс хэтрэхгүй байна.

Хүснэгт 1.2 Гүйцэтгэгчийн гэрээт ажлын дүн

№	Зардлын нэр	Бүгд өртөг /төгрөг/	Төлбөрт эзлэх хувь
1	Авто зам, замын байгууламж	390,044,496,839.00	165,810.23
2	Гүүр, гүүрэн байгууламж	1,401,041,540,314.24	595,591.06
3	Туннель	386,309,417,827.72	164,222.42
4	Ус, дулаан, борооны ус зайлуулах, бохир	26,124,396,596.00	11,105.63
5	Цахилгааны шугам сүлжээ, дэд станц, гэрэлтүүлэг, мэдээлэл холбоо	115,488,947,732.11	49,095.04
6	Мэдээлэл холбоо камержуулалт, удирдлага-төлбөрийн систем	11,518,223,650.00	4,896.46
7	Ногоон байгууламж	21,827,876,343.14	9,279.16
8	**ШУУД ЗАРДЛЫН ДҮН (1+2+3+4+5+6+7)**	**2,352,354,899,302.21**	**1,000,000.00**
9	Техник, технологийн хяналт, зөвлөх үйлчилгээний зардал	71,760,909,370.92	
10	Зураг төсөл зохиогчийн хяналт	1,531,315,683.00	
11	Магадлашгүй ажлын зардал	64,631,651,957.35	
12	Нэмэгдсэн өртгийн албан татвар	234,158,160,112.54	
13	Норм, нормативийн сангийн шимтгэл	7,527,292,477.63	
	НИЙТ ӨРСӨЛДӨӨНТ ҮНЭ (8+9+10+11+12+13)	**2,731,964,228,903.65**	

*Жич: Хүснэгт 1.1 болон хүснэгт 1.2 дахь үнэ дээр тендерт оролцогч үнийн саналаар өрсөлдөнө.

*Магадлашгүй ажлын мөнгөн дүнг технологийн хувьд зайлшгүй шаардлагатай ТЭЗҮ, Гэрээнд тусгагдаагүй нэмэлт ажлыг гүйцэтгүүлэх зорилгоор Монгол Улсын хууль, дүрэмд нийцүүлэн Ажлын төлбөрт шилжүүлэн тооцож болно. Хэрэв магадлашгүй ажлыг Монгол Улсын хууль, дүрэмд зааснаар зарцуулаагүй бол Захиалагчид үлдэнэ.

**Гүйцэтгэгчийн гэрээт ажлын дүнд менежментийн зардал, гүйцэтгэгчийн ашиг, ХАБЭА-н үйл ажиллагааны зардал, норм нормативын сангийн зардал, инженерийн хэмжилт, хайгуул судалгаа, төслийн техник технологийн хяналт, зөвлөх үйлчилгээ, бүхий л даатгал, нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татвар болон үйл ажиллагаа явуулах, төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, дүрэм, журамд заасан бүхий л төлбөр, хураамж зэрэг гүйцэтгэгчтэй холбоотой бүхий л зардлыг шингээн тооцсон.

1.2. Захиалагч нь эрх бүхий этгээдийн магадалсан нарийвчилсан зураг төсөл, хэмжилтээр тодорхойлсон Ажлын нэр, төрөл, тоо хэмжээг баримтлан Гэрээнд заасан тухайн Ажил (ажилбар)-ын “Төлбөрт эзлэх хувь”-ийг өөрчлөхгүйгээр гүйцэтгэсэн Ажлын нэр, төрөл, тоо хэмжээг дүйцүүлэн Явц дундын төлбөрийг тооцож төлнө.

1.3. Төлбөрт эзлэх хувийг 1,000,000.00 нэгжээр тэмдэглэв.

1.4. Технологийн хувьд зайлшгүй бөгөөд илүү оновчтой хувилбарыг сонгох бодит шаардлагын хүрээнд энэхүү хавсралтын 8 дугаар зүйлд нэрлэн заагаагүй нэмэлт ажил (ажилбар)-ыг гүйцэтгүүлэхээр Талууд харилцан тохиролцсон тохиолдолд Гүйцэтгэгчийн гэрээт ажлын нийт үнийн дүнг өөрчлөхгүйгээр, ийнхүү нэмэгдсэн буюу хэтэрсэн ажил (ажилбар)-ын өөрчлөлтийг бусад Ажлын “Төлбөрт эзлэх хувь”-ийг нь дүйцүүлж шилжүүлэх байдлаар Ажлын нийт тоо хэмжээнд багтаан гүйцэтгэж болно.

1.5. Энэ зүйлийн 1.4.-т заасан өөрчлөлтийг Гэрээний нөхцөлийн дагуу Захиалагчийн зааварчилгааг үндэслэн тухай бүр зураг төсөлд тусгасан байна.

1.6. Магадалшгүй ажлын нөөц хөрөнгийг Монгол Улсын хуульд зааснаар дор дурдсан зориулалтаар зарцуулна. Үүнд:

a) Магадлагдсан зураг төсөл болон гүйцэтгэлийн зургийн тоо хэмжээ нь Гэрээнд заасан Ажлын тоо хэмжээнээс хэтэрсэн, ТЭЗҮ болон Гэрээнд тусгагдаагүй технологийн хувьд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн ажил;

b) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас гарсан нэмэлт ажил болон үйл ажиллагааны зардлууд;

c) ТЭЗҮ, зураг төсөл магадлагдсаны дараа илрүүлсэн төсвийн тооцооны алдааг залруулах;

d) Барилгын материал хийц хэсгийг зураг төсөл зохиогчийн зөвшөөрөлтэйгөөр өөрчилснөөс үүдэн гарах аливаа зардлууд;

e) Ажлын баримт бичгийн төслийн шийдлийн өөрчлөлтийн зөрүү;

f) Захиалагчийн шаардлага, хүсэлтийн дагуу аливаа шалтгаанаар гүйцэтгэсэн бусад ажил болон үйлчилгээ.

2. УРЬДЧИЛГАА ТӨЛБӨР

2.1. Хэрэв Урьдчилгаа төлбөрийг олгох тохиолдолд тухайн төлбөрөөр санхүүжүүлэх ажлын нэр, төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хувиарыг Талууд харилцан тохиролцож Захиалагчид ирүүлнэ.

2.2. Урьдчилгаа төлбөрийн баталгааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйл, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/252 дугаар тушаалд заасны дагуу гаргана.

3. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

3.1. Гүйцэтгэгч энэхүү хавсралтын 8 дугаар зүйлд заасан Ажлыг магадлагдсан зураг төслийн дагуу зохих ёсоор гүйцэтгэсэн бөгөөд энэ нь Захиалагчийн хянан баталгаажуулсан гүйцэтгэлийн баримт бичгээр баталгаажсан бол Захиалагч тухайн Ажлын төлбөрийг Гүйцэтгэгчид бүрэн төлөх үүрэгтэй.

3.2. Техник технологийн хяналт, зөвлөх үйлчилгээний зардал, НӨАТ-ын зардлыг тухайн Ажлын гүйцэтгэлээрх Шууд зардлын дүн (Хүснэгт 1.2-н 8 дугаар мөр)-д эзлэх хувь, хэмжээгээр тооцон Явц дундын төлбөр (IPC) бүрээр Гүйцэтгэгчид төлнө.

3.3. Гүйцэтгэгч төслийг бүхэлд нь энэхүү гэрээний хавсралт 5-т заасан хугацаанд багтаан ашиглалтад оруулна.

3.4. Гэрээний төлбөрийн нөхцөл нь Санхүүжилтийн гэрээнд өөрөөр заагдсан бол Санхүүжилтийн гэрээнд дурдсанаар хэрэглэнэ.

4. ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ТОХИРУУЛГА

4.1. Талууд Гэрээний үнэд шатахуун болон Барааны зах зээлийн үнийн өөрчлөлтөөс үүдэлтэй үнийн тохируулга, өөрчлөлт оруулахгүй байхаар харилцан тохиролцож, Гүйцэтгэгч үнийн хэлбэлзлийн эрсдэлийг дангаар хариуцахыг хүлээн зөвшөөрөв.

4.2. Ажил (ажилбар)-ын “Төлбөрт эзлэх хувь” нь Явц дундын төлбөрийн хэмжээг тодорхойлоход ашиглах хэрэглүүр бөгөөд энэ нь тухайн Ажлын нийт үнийн дүнд нөлөөлөхгүй.

5. ЯВЦ ДУНДЫН ТӨЛБӨР

5.1. Гүйцэтгэгч нь Явц дундын төлбөрийн хүсэлтийг Гэрээний нөхцөлд заасны дагуу боловсруулж, Захиалагчид хүргэх үүрэгтэй.

5.2. Гүйцэтгэсэн ажлын хувийг гаргахдаа магадлагдсан зураг төслийн ажилбар бүрийн Төлбөрт эзлэх хувийг нийт ажилд харьцуулан тодорхойлно. Ингэж тодорхойлсон ажлын гүйцэтгэлийн хувийг Гүйцэтгэгчийн гэрээт Ажлын нийт үнэд жинлэж Явц дундын төлбөрийн хүсэлтийг хүргүүлнэ.

5.3. Гүйцэтгэгч нь төлбөрийн баталгаажуулалтад шаардлагатай гүйцэтгэлийн зураг, холбогдох баримт бичгийг боловсруулахдаа ажлын бодит гүйцэтгэлийг нотлох, баталгаажуулж буй ажилд хамаарах барилга угсралтын болон санхүүгийн баримт бичиг, мэдээллийг Захиалагчид гаргаж өгөх үүрэгтэй.

6. АЖИЛ

6.1. Гүйцэтгэгч нь Ажлыг энэ гэрээний хавсралт №1 [Захиалагчийн шаардлага]-т зааснаар чанарын өндөр түвшинд нийцүүлэн гүйцэтгэх ба ажлыг гүйцэтгэх зорилгоор боловсруулсан болон гүйцэтгэсэн Ажилд энэ зүйлд заасан төлбөрийн нөхцөл үйлчилнэ.

Төслийн барилга угсралтын ажлын өмнө энэхүү хавсралтын хүснэгт 8.1.Авто зам, замын байгууламж; хүснэгт 8.2.Гүүр, гүүрэн байгууламж; хүснэгт 8.3.Туннел; хүснэгт 8.4.Ус, дулаан, борооны ус зайлуулах, бохир; хүснэгт 8.5.Цахилгааны шугам сүлжээ, дэд станц, гэрэлтүүлэг, мэдээлэл холбоо; хүснэгт 8.6.Мэдээлэл холбоо камержуулалт, удирдлага-төлбөрийн системд тус тус туссан Ажлуудын төлбөрт эзлэх хувьд багтсан зураг төсөл, бэлтгэл ажилд Явц дундын төлбөрийг дараах нөхцөлөөр баталгаажуулж болно. Жишээлбэл:

6.1.1. Ажлын зураг төслийг тухайн төлбөрт эзлэх хувийн 10%-иар;

6.1.2. Бэлтгэл ажлыг тухайн төлбөрт эзлэх хувийн 15%-иар г.м.

7. БАРАА МАТЕРИАЛ – БЭЛТГЭЛ АЖИЛ

7.1. Гүйцэтгэгч нь Ажлын зориулалтаар нийлүүлж буй тогтмол бус бөгөөд Гэрээний нөхцөлийн Хавсралт №1 [Захиалагчийн шаардлага]-т заасан техникийн шаардлагад нийцсэн Барааг нийлүүлэх ба энэхүү зорилгоор худалдан авсан, хадгалсан Бараанд энэ зүйлд заасан төлбөрийн нөхцөл үйлчилнэ.

7.2. Төслийн барилгын ажлын үед шаардагдах цемент, арматур, битум, түлш, туузан хашлага, гэрэлтүүлэг, туннель, гүүрийн тусгай зориулалтын машин механизм болон бусад тоноглолд Явц дундын төлбөрийг дараах нөхцөлөөр баталгаажуулна:

7.2.1. Тухайн Барааны нийт үнийн дүнгийн 30%-тай тэнцэх төлбөрийг тухайн Бараа үйлдвэрлэгч, нийлүүлэгчтэй гэрээ байгуулснаар;

7.2.2. Тухайн Барааны нийт үнийн дүнгийн 15%-тай тэнцэх төлбөрийг Үйлдвэрлэгчийн үйлдвэр эхэлсэн тухай мэдэгдлийг үндэслэн Барааг үйлдвэрлэж эхлэхийн өмнө;

7.2.3. Тухайн Барааны нийт үнийн дүнгийн 20%-тай тэнцэх төлбөрийг тухайн Барааг үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн талбайгаас тээвэрлэснээр;

7.2.4. Тухайн барааны нийт үнийн дүнгийн 20%-тай тэнцэх төлбөрийг тухайн Барааг талбайд хүргэснээр;

7.2.5. Тухайн Барааны нийт үнийн дүнгийн 15%-тай тэнцэх төлбөрийг тухайн Барааг Захиалагчийн шаардлагад нийцүүлэн угсарч суурилуулж дууссаны дараа төлнө.

7.3. Гүйцэтгэгч энэ зүйлийн 7.2.3-т заасан төлбөр бүрийн өмнө хүчин төгөлдөр нэхэмжлэх (эсхүл Явц дундын төлбөрийн хүсэлт)-ийг үйлдвэрлэгчийн багц, баглаа боодлын жагсаалт (packing list)-ын хамт Захиалагчийн эрх бүхий төлөөлөгчид хүргэнэ.

7.4. Энэ гэрээний дагуу санхүүжүүлсэн хөрөнгийн эх үүсвэрээр Гүйцэтгэгч худалдан авсан буюу худалдан авахаар туслан гүйцэтгэгч болон бусад этгээдийн өмнө төлбөрийн үүрэг хүлээсэн, энэ зүйлийн 7.2-т хамаарах Хавсралтын 8 дугаар зүйлд заасан тоо хэмжээ бүхий чанарын доголдолгүй Барааг Захиалагч хүлээн авч төлбөрийг төлөх бөгөөд Захиалагчийн өмч мөн.

8. АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ - ДЭЛГЭРЭНГҮЙ

8.1. Энэхүү гэрээний үнэ нь нийт үнэд үндэслэн /LUMP SUM/ нөхцөлөөр зөвшөөрсөн үнэ байх бөгөөд ажлын тоо хэмжээний задаргааг Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлыг баталгаажуулахад ашиглана.

8.2. Ажлын тоо хэмжээний хүснэгтэд дурдагдаагүй боловч гэрээнд заасан ажлын зорилгод хүрэхийн тулд зайлшгүй хийгдэх ажил, Гэрээгээр хийж гүйцэтгэхээр тохиролцсон ажил, түүний салшгүй хэсэг нь Гэрээний нийт төлбөрт багтсан байна.

8.3. Энэ зүйлийн 8.2.-т заасан Ажлын тоо хэмжээний хүснэгтэд дурдсан тоо хэмжээ нь төслийн магадлагдсан техник эдийн засгийн үндэслэлд дурдсан тоо хэмжээтэй зөрвөл техник эдийн засгийн үндэслэлд дурдсан тоо хэмжээг баримтална.

8.4. Эрх бүхий этгээдийн магадалсан, нарийвчилсан зураг төслийн тоо хэмжээг талууд баримталж ажиллах бөгөөд бүх ажлын зураг төсөл магадлагдсаны дараа доорх тоо хэмжээ, төлбөрт эзлэх хувийн хүснэгтийг шинэчилж батална.

8.5. Захиалагч хүлээн зөвшөөрч, эрх бүхий этгээдийн магадалсан нарийвчилсан зураг төсөл, хэмжилтээр тодорхойлсон Ажлын нэр, төрөл, тоо хэмжээний дагуу Гүйцэтгэгч Ажлыг гүйцэтгэнэ.

Хүснэгт 8.1. Авто зам, замын байгууламж

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төлбөрт эзлэх хувь
1	**Авто зам, замын байгууламж**			**165,039.35**
1.1	Түр барилга, бэлтгэл	багц	1	34.43

1.2	Замыг чиг сэргээх	км	24.8	24.22
1.3	Ззамын трасс, талбай цэвэрлэх ажил	м3	5,925	924.84
1.4	Газар шорооны ажил	км	24.8	51,390.49
1.5	Хөрс солих	м3	387,530	7,327.68
1.6	Замыг хайрган хөвөө байгуулах	м3	736	181.32
1.7	Түр болон туслах замын ажил	км	15	122.54
1.8	Замын суурийн ажил	м3	261,414	16,699.70
1.9	Хучилтын ажил	м2	575,510	20,304.89
1.10	Замын хашлага байрлуулах	метр	214,229	12,344.55
1.11	Явган хүний замын ажил	м2	125,794	3,995.50
1.12	Унадаг дугуйн замын ажил	м2	242,574	11,855.15
1.13	Замын тоноглол ажил	багц	1	3,224.81
1.14	Хамгаалалтын хашлаганы ажил	м3	2,889	2,042.87
1.15	Далангийн хажууг ногоон байгууламжаар бэхлэх	м3	24,169	13,830.05
1.16	Ус зайлуулах байгууламжын ажил	км	24.8	17,211.37
1.17	Ус зайлуулах төмөрбетон хоолойн ажил	км	24.8	3,455.07
1.18	Авто замын байгууламжыг улсын ашиглалтад оруулах	км	24.8	20.18
1.19	Үйлдвэр завод ачиж буулгах хураах ажил	багц	1	49.68

Хүснэгт 8.2. Гүүр, гүүрэн байгууламж

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төлбөрт эзлэх хувь
2	**Гүүр, гүүрэн байгууламж**			**592,684.33**
2.1	Гүүр-1 (6 эгнээ, шон суурьтай төмөрбетон гүүр)	метр	2,951	131,103.74
2.2	Гүүр-2 (6 эгнээ, угсармал болон цутгамал хайрцган дам нуруут гүүр)	метр	1,078	53,613.61
2.3	Гүүр-3 (К1300 холбоос орж гарах гүүр)	метр	520	8,763.96
2.4	Гүүр-4 (огтлолцох, угсармал дам нуруутай)	метр	270	5,219.63
2.5	Гүүр-5 (2-р тойрог замын баруун уулзвартай холбогдох, угсармал болон цутгамал)	метр	1,286	31,566.04
2.6	Гүүр-6 (туслах замын явган хүний гүүр, угсармал хайрцган дам нуруу)	метр	100	2,202.62
2.7	Гүүр-7 (явган хүний гүүр, угсармал хайрцган дам нуруу)	метр	128	3,020.71
2.8	Гүүр-8 (2*5*5м хэмжээстэй төмөр бетон жаазан гүүр)	метр	60	3,144.10
2.9	Гүүр-9 (Энхтайвны Ө.Ч баруун гүүрэн гарц, цутгамал дам нуруутай)	метр	660	19,022.69
2.10	Гүүр-10 (6 эгнээ, угсармал болон цутгамал хайрцган дам нуруут гүүр)	метр	2,315	107,404.94

2.11	Гүүр-11 (Долоон буудлын замын уулзвартай холбогдох холбоос замын гүүр)	метр	986	30,358.95
2.12	Гүүр-12 (Туслах гүүр)	метр	60	1,514.15
2.13	5х5 хэмжээтэй хос хиймэл байгууламж	метр	107	4,175.11
2.14	Гүүр-14 (6 эгнээ, угсармал болон цутгамал хайрцган дам нуруут гүүр)	метр	2,570	115,703.90
2.15	Гүүр-15 (Туслах гүүр)	метр	120	7,036.28
2.16	Гүүр-16 (Туулын хурдны замтай огтлолцох хэсгийн гүүр)	метр	520	27,894.92
2.17	Гүүр-17 (Энхтайвны өргөн чөлөөтэй холбогдох уулзварын гүүр)	метр	1140	18,412.56
2.18	Гүүр-18 (Хоёрдугаар тойрог замтай холбогдох уулзварын гүүр)	метр	290	13,220.53
2.19	Гүүр-19 (Явган хүний гүүр)	метр	64	1,523.12
2.20	Гүүр-20 (4х4 хэмжээтэй 3ш, 5х5 хэмжээтэй хос 2ш хиймэл байгууламж)	метр	341	7,782.76

Хүснэгт 8.3. Туннел

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төлбөрт эзлэх хувь
3	**Туннел**			**168,123.20**
3.1	Газар шорооны ажил	м3	798,872	150,721.45
3.2	Замын хөдөлгөөн	метр	2,080	247.96
3.3	Агааржуулалт	шир	32	472.48
3.4	Гал хамгаалах	багц	1	583.74
3.5	Цахилгаан (кабелийн уртаар)	Метр	64,020	2,296.11
3.6	Гэрэлтүүлэг	метр	4,160	1,162.62
3.7	Хяналт, үзлэг	багц	1	1,310.56
3.8	Төслийн арга хэмжээ	шир	1	352.36
3.9	Галын насосны өрөө	багц	1	244.51
3.10	Хуваарилах байр	багц	1	319.94
3.11	Галын усан сан	багц	1	73.49
3.12	Тарифын зохицуулалтын зардал	багц	1	10,337.98

Хүснэгт 8.4. Ус, дулаан, борооны ус зайлуулах, бохир

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төлбөрт эзлэх хувь
4	**Ус, дулаан, борооны ус зайлуулах, бохир**			**11,051.44**
4.1	Гадна цэвэр ус	багц	1	1,229.59
4.2	Гадна дулаан	багц	1	1,228.67
4.3	Борооны усны шугам хоолой	багц	1	8,363.42
4.4	Ус хангамж, ариутгах татуурга	багц	1	229.75

Хүснэгт 8.5. Цахилгааны шугам сүлжээ, дэд станц, гэрэлтүүлэг, мэдээлэл холбоо

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төлбөрт эзлэх хувь
5	**Цахилгааны шугам сүлжээ, дэд станц, гэрэлтүүлэг, мэдээлэл холбоо**			**53,080.83**
5.1	гадна холбоо зөөх шилжүүлэх	багц	1	271.88
5.2	Шинээр хийх гадна холбоо	багц	1	3,953.52
5.3	Гэрэлтүүлэг	багц	1	12,125.49
5.4	Гадна гэрэлтүүлгийн КТПН	багц	1	270.00
5.5	Гадна цахилгаан хангамж	багц	1	36,459.93

Хүснэгт 8.6. Мэдээлэл холбоо камержуулалт, удирдлага-төлбөрийн систем

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төлбөрт эзлэх хувь
6	**Мэдээлэл холбоо камержуулалт, удирдлага-төлбөрийн систем**			**786.99**
6.1	Дөрвөн замын уулзварт суурилуулах	шир	11	298.66
6.2	Замын хяналтын камер	шир	16	27.50
6.3	Тууш замд суурилуулах	шир	27	460.83

Хүснэгт 8.7. Ногоон байгууламж

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төлбөрт эзлэх хувь
7	**Ногоон байгууламж**			**9,233.87**
7.1	Мод, ургамал тарих ширхэгийн	ширхэг	76,736	3,598.50
7.2	Мод, ургамал тарих талбайгаар	м2	514,205	5,206.12
7.3	Бусад	багц	1	429.25

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ №2-Д ЗААСАН БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮД:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:	ГҮЙЦЭТГЭГЧ
Нийслэлийн засаг даргын тамгын газрын дарга	“.....”
	ТӨЛӨӨЛЖ:

ХАВСРАЛТ 3. БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ БОЛОН НИЙГМИЙН УДИРДЛАГА

БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ БОЛОН НИЙГМИЙН УДИРДЛАГА

1. УДИРТГАЛ

1.1. Гүйцэтгэгч нь дараахь баримт бичгүүдийг үндэслэн “Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлагын төлөвлөгөө” (цаашид “БОХАБЭАНУ-ын төлөвлөгөө” гэх) боловсруулж, Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангаж ажиллана. Үүнд:

a) Захиалагчийн байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлагын талаарх баримтлах бодлого, журам (Хавсралт №3-ын 2-т заасан);
b) Захиалагчийн байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлагын төлөвлөгөөнд тавигдах ерөнхий шаардлага (“Хавсралт №3-ын 3”-т заасан);
c) Тус төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан.

1.2. БОХАБЭАНУ-ын төлөвлөгөөнд орон нутгийн байгаль орчин, нийгэмд үзүүлж болох боломжит сөрөг нөлөөллийг зохицуулах, бууруулах, аюулгүй байдлыг хангах, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үүрэг, хариуцлагыг тусгах бөгөөд энэхүү төлөвлөгөөгөөр эерэг өөрчлөлтийг бий болгох зорилготой.

1.3. Захиалагч нь байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлагын талаар баримтлах бодлого, журам, тавигдах шаардлагад өөрчлөлт оруулж болно. Гүйцэтгэгч нь аливаа өөрчлөлтийг нэн даруй хэрэгжүүлж, өөрөөр зөвлөөгүй бол өөрийн төлөвлөгөө, журмаа шинэчлэх замаар дагаж мөрдөнө.

2. ЗАХИАЛАГЧИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ БОЛОН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ТАЛААРХ БАРИМТЛАХ БОДЛОГО, ЖУРАМ

Захиалагчийн байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлагын талаарх баримтлах бодлого, журамд үндэслэн Гүйцэтгэгч нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой хууль тогтоомж стандарт, хэм хэмжээг хэрэгжүүлнэ.

Энэхүү бодлого, дүрэм, журмыг “Ажил эхлүүлэх тухай мэдэгдэл” ирүүлснээс хойш энэхүү Хавсралт 3-д тусгайлан заасны дагуу 30 хоногийн дотор Захиалагч Гүйцэтгэгчид гаргаж өгнө.

3. БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ БОЛОН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Гүйцэтгэгч нь байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлагын талаарх баримтлах бодлого, журамтай холбоотой дараахь шаардлагуудыг дагаж мөрдөнө. Үүнд:

3.1. БАЙГАЛЬ ОРЧИН

a) Гүйцэтгэгч нь байгаль орчныг хамгаалах (ажлын талбайн гадна болон дотор), элэгдэл, бохирдлоос урьдчилан сэргийлэх, байгаль орчинд халтай үйл ажиллагаанаас шалтгаалан хүрээлэн буй орчин, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол үүсэхээс сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авна.
b) Гүйцэтгэгч нь Захиалагчийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар магадлуулсан жил тутмын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дагаж мөрдөх ба төлөвлөгөөнд тусгагдсан байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлж байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
c) Гүйцэтгэгч нь Захиалагчийн байгаль орчны талаарх үйл ажиллагааны журам, шийдвэрийг дагаж мөрдөнө.
d) Гүйцэтгэгч нь хог хаягдалтай холбоотой хууль тогтоомж, шаардлагуудыг мөрдлөг болгон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг боломжит түвшинд хүртэл бууруулах үүрэг хүлээнэ.
e) Гүйцэтгэгч нь ан амьтан, ургамал, агаарын чанарыг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд холбогдох хууль, журамд заасан шаардлагуудыг дагаж мөрдөнө.
f) Гүйцэтгэгч түр кемпийн газар, төслийн түр зам ашиглах зөвшөөрлүүдийг эрх бүхий байгууллагаас гаргуулан авах үүрэгтэй. Мөн түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрхийн хүрээнд түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах үүрэгтэй. Гүйцэтгэгч нь холбогдох хууль, журмын дагуу төлбөрийг төлж ашиглалт дуусаны дараа нөхөн сэргээлтийг хийн хүлээлгэн өгөх үүргийг хүлээнэ.
g) Гүйцэтгэгч нь химийн бодисын хаягдал, материалын алдагдал хүрээлэн буй орчин, ургамал, ан амьтад, хөрс, гадаргын болон газрын доорх усанд үзүүлсэн сөрөг нөлөөлөл, бохирдол зэрэг байгаль орчны зөрчил, осол аваарын талаар мэдээллийг Захиалагчид тухай бүр тогтмол мэдэгдэж байна. Гүйцэтгэгч нь сар бүрийн тайлангийн нэг хэсэг болгож байгал орчны тайланг Захиалагчид хүргүүлнэ.
h) Гүйцэтгэгч төслийн үйл ажиллагаанаас шалтгаалах элэгдэл, хорогдол, асгаралт, хаягдлын хэмжээ, ус зарцуулалтыг Техникийн шаардлага болон холбогдох хууль тогтоомжид заагдсан хэмжээнээс хэтрэхгүй байлгах үүрэгтэй.

3.2. АЖЛЫН ТАЛБАЙН МЕНЕЖМЕНТ

a) Гүйцэтгэгчийн ажлын талбай гэдэгт ажлын шаардлагаар ашиглаж буй байнгын болон түр талбайг хамруулан ойлгох ба зөвшөөрсөн газруудад тэмдэг, тэмдэглэгээ байршуулна. Гүйцэтгэгч нь өөрийн тоног төхөөрөмж, ажиллах хүчийг ажлын талбайд байршуулах болон ажил гүйцэтгэхэд шаардлагатай арга хэмжээг авна.
b) Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч нь ажлын талбайг аливаа саадаас ангид байлгаж, Гүйцэтгэгч нь барилгын ажлын улирал бүрийн төгсгөлд ажлын талбайгаас хаягдал материалыг устгаж зайлуулах арга хэмжээ авна.

c) Гүйцэтгэгч нь барилгын ажлын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгаж, стандарт шаардлагыг удирдамж болгон ТТАМ орд болон түр замыг нөхөн сэргээх ба ажилд үл хамаарах тээврийн хэрэгсэл зорчихгүй байлгах, хамгаалах арга хэмжээг авна.
d) Гүйцэтгэгч нь ажлын талбайд зөөвөрлөн авчирсан химийн болон аюултай материалыг хадгалах, зайлуулах, устгах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу гүйцэтгэж, ажлын талбайг цэвэрлэж, аюулгүй байдлыг хангана.

3.3. ЭРҮҮЛ АХУЙ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖМЕНТ

a) Гүйцэтгэгч нь хууль тогтоомжид заасан Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагуудыг дагаж мөрдөх бөгөөд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарахаас урьдчилан сэргийлж, ажиллах хүчний аюулгүй байдлыг бүрэн хангана.
b) Гүйцэтгэгч нь ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжид заасан тоогоор хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны болон эрүүл ахуйн ажилтан ажиллуулна.
c) Гүйцэтгэгч нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны осол, осолд дөхсөн тохиолдлуудыг тайлагнах тогтолцоотой байх бөгөөд уг тайланг сар тутмын явцын тайланд тусгасан байна.

3.4. НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТ

a) Гүйцэтгэгч нь нийгмийн өв уламжлалыг хадгалах, хамгаалах, түүхийн болон соёлын үнэт зүйлсийг хамгаалах, орон нутгийн оршин суугчид, малчид, засгийн газрын болон төрийн бусад байгууллагуудад сонирхогчийн түвшинд мэдээлэл гаргаж өгөх, оролцох, аливаа хүсэлт, шаардлага, гомдолд хариу өгөх зэргээр хамтын ажиллагааг явуулна.
b) Гүйцэтгэгч нь орон нутгийн уламжлалыг хүндэтгэж, эдийн болон эдийн бус соёлын эд зүйлсийг хүндэтгэнэ.
c) Гүйцэтгэгч нь нийт ажиллах хүчний 20-иос доошгүй хувийг мэргэжлийн шаардлага хангасан орон нутгийн иргэдийг ажлын байраар хангана.
d) Гүйцэтгэгч нь Захиалагчтай орон нутгийн эдийн засгийг дэмжихэд хамтран ажиллах бөгөөд орон нутгаас эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан бараа, ажил, үйлчилгээ худалдан авахыг хичээнэ.
e) Гүйцэтгэгч нь гомдол барагдуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх бөгөөд орон нутгийн иргэдээс ирсэн аливаа гомдлыг цаг тухайд нь (хамгийн ихдээ 30 өдөр, шаардлагатай бол илүү хурдан хугацаанд) хариу өгч, барагдуулах бөгөөд орон нутгийн иргэд, ажилчид, туслан гүйцэтгэгчдээс ирсэн аливаа гомдолтой холбоотой шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлнэ. Мөн түүнчлэн, гүйцэтгэгч нь орон нутгийн иргэд, туслан гүйцэтгэгч, ажилчдаас ирсэн гомдлыг сар бүр тайлан болгон бэлтгэж, тэдгээр гомдлыг хэрхэн барагдуулах боломжтой эсэх талаар Захиалагчтай зөвлөлдөнө. Гүйцэтгэгчийн хариуцлагагүй үйл ажиллагаанаас болж Захиалагч болон гомдол гаргагчид мөнгөн болон

материаллаг хохирол үүссэн бол бүх хохирол, зардлыг Гүйцэтгэгч барагдуулна.

3.5. БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ БОЛОН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВИГДАХ БУСАД ШААРДЛАГА

a) Захиалагч нь Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд гэнэтийн болон хугацаат үзлэг хийнэ. Гүйцэтгэгч нь ажлын байрны үзлэгээр илэрсэн зөрчил, үл нийцлийг арилгах үүрэгтэй.
b) Захиалагч нь БОХАБЭАНУ-ын төлөвлөгөөг биелүүлээгүй, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, тогтоомжийг зөрчсөн, тайланг хоцроосон зэрэг тохиолдол бүрт 5.000.000 - 10.000.000 төгрөгийн торгуулийг Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авна.
c) Төслийн зам, барилгын ажилд ашигласан ТТАМ орд, кемпийн газар, түр зам зэрэг Гүйцэтгэгчийн зүгээс нөхөн сэргээх шаардлагатай газруудыг холбогдох албан тушаалтанд албан ёсоор хүлээлгэн өгөх хүртэл нөхөн сэргээлтийн зардлыг Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс барьцаа хэлбэрээр Захиалагчийн дансанд саатуулна.

Гарын үсэг арын хуудсанд

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ №3-Д ЗААСАН БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮД:

ЗАХИАЛАГЧ “.....”-ИЙГ ТӨЛӨӨЛЖ: ДАРГА	ГҮЙЦЭТГЭГЧ “.....” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХАВСРАЛТ №4

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ ЗӨВШӨӨРӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ҮҮРГИЙН МАТРИЦ

/“.....” болон “.....” ХХК-ийн хооронд 2025 оны ..... дугаар сарын .....-ны өдөр байгуулав./

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ ЗӨВШӨӨРӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ҮҮРГИЙН МАТРИЦ

№	Ажилбар	Захиалагч	Гүйцэтгэгч	Хугацаа
1	**Зохион байгуулалтын арга хэмжээнүүд**			
1.1	БОННҮ, БОМТ боловсруулах, магадлуулах	Х		
1.2	Монгол Улсын хилээр оруулж ирэхтэй холбоотой ажиллах хүч, тоног төхөөрөмж, машин механизм, бараа материалын аливаа зөвшөөрөл, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах	Х	ХТ	Тухай бүр
1.3	Авто замтай огтлолцсон зам болон бусад дэд бүтцийн байгууламжийн техникийн нөхцөл, шийдлийг холбогдох талуудтай тохирох	Д	Х	Тухай бүр
1.4	Байгаль орчны хамгааллын арга хэмжээг авч ажиллах		Х	
2	**Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, захиргааны байгууллагаас авах зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл**			
2.1	Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл авах	Д	Х	
2.2	Авто зам, замын байгууламжийн барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл авах	Д	Х	
2.3	Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгоход бүрдүүлэх бичиг, баримт	Х	Х	
2.4	Газар эзэмшүүлэх зөвшөөрөл	Х	Т	
2.5	Авто замын зурвас газрыг батлуулах	Х	Х	
2.6	Авто замын ажилд ашиглах хэмжих багаж хэрэгслийн гэрчилгээжүүлэлт	Д	Х	Тухай бүр /Гүйцэтгэгч, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн нэр дээр байх/
2.7	Авто замын ажилд хэрэглэх өөрөө явагч машин механизмын гэрчилгээжүүлэлт	Д	Х	Тухай бүр /Гүйцэтгэгч, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн нэр дээр байх/
2.8	Бараа, материалын чанарын болон тохирлын гэрчилгээ		Х	Тухай бүр /Гүйцэтгэгч, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн нэр дээр байх/
2.9	Мэдээлэл, холбооны болон ЦДАШ, дэд станцын тоног төхөөрөмжийн гэрчилгээ		Х	
2.10	Газар чөлөөлөлт	Х	Д	

Захиалагч тэмдэг Гүйцэтгэгч тэмдэг

Бүлэг VI: Хавсралт 4-Ажил гүйцэтгэхэд шаардагдах зөвшөөрөл, арга хэмжээг авч хэрэгжүүлэхтэй холбоотой үүргийн матриц

№	Ажилбар	Захиалагч	Гүйцэтгэгч	Хугацаа
3	**Орон нутгийн байгууллагаас**			
3.1	Кемпийн зөвшөөрөл	Д	Х	Тухай бүр
3.2	Түр замын зөвшөөрөл	Д	Х	Тухай бүр
3.3	Хог хаягдлын түр цэгийн зөвшөөрөл	Д	Х	Тухай бүр
3.4	ТТАМ ашиглалтын зөвшөөрөл	Д	Х	Тухай бүр
3.5	Ус ашиглалтын зөвшөөрөл	Д	Х	Тухай бүр
3.6	Хийх ажлын нарийвчилсан төлөвлөгөөний хяналт, баталгаажилт	Х	Х	Тухай бүр
4	**Ашиглалтад оруулах**	Х	Х	
4.1	Ашиглалтад оруулахад шаардлагатай эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрүүд /Улсын комиссын шаардлага хангасан байдлаар/	Х	ХТ	Тухай бүр
4.2	Улсын комисст хүлээлгэх өгөх хүсэлт гаргах	Х	ХТ	Тухай бүр
4.3	Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авахад бүрдүүлэх, архивт хүлээлгэн өгөх бичиг, баримтыг хангуулах	Х	Х	Тухай бүр
4.4	ЗТХС-ын 2018 оны 49-р тушаалаар баталсан "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам"-д заасан шаардлагыг бүрэн хангах	Д	Х	Тухай бүр
4.5	Төсөлд ашигласан олон улсын барилга угсралт, ашиглалт, засвар үйлчилгээний стандартуудыг орчуулж, боловсруулж Захиалагчид өгөх		Х	Тухай бүр
5	**Авто зам, замын байгууламжийн гэрчилгээжүүлэлт**	Х	Д	

Х-Хариуцна /Хэрэв Т буюу төлбөр тусдаа тусгагдаагүй бол үүнд төлбөр багтсан гэж ойлгоно./
Т-Төлбөр төлнө
Д-Дэмжинэ

Гэрээнд заасан ажилд зөвхөн энэхүү матрицыг мөрдөнө. Матрицад дурдсан арга хэмжээ, зөвшөөрлүүд нь эцсийнх биш бөгөөд Гэрээг хэрэгжүүлэх хугацаанд дахин шинэчлэх боломжтой.

Захиалагч тэмдэг Гүйцэтгэгч тэмдэг

Гарын үсэг арын хуудсанд

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ 4-Т ЗААСАН БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦАЖ,
ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ	ГҮЙЦЭТГЭГЧ
“.....”-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:	“.....” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ДАРГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Захиалагч тэмдэг

Гүйцэтгэгч тэмдэг

ХАВСРАЛТ №5

АЖЛЫН ХУВААРЬ

/“.....” болон “.....”-ын хооронд 2025 оны ....дугаар сарын....-ны өдөр байгуулав./

№	Зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ажил Нэгдүгээр тойрог зам	Гүйцэтгэх хугацаа Сар	эхлэх	дуусах
1	**Төслийн зураг төсөл, барилга угсралт, хүлээлгэн өгөх ажил**	**36**	**2025.11.10**	**2028.11.10**
1.1	**Зураг төсөл боловсруулах ажил**	**8**	**2025.11.10**	**2027.06.10**
1.1.1	Урьдчилсан зураг төсөл төлөвлөлт, инженерийн хэмжилт, хайгуул, судалгаа	2	2025.11.15	2026.01.15
1.1.2	Нарийвчилсан зураг төсөл боловсруулалт	6	2025.12.10	2025.06.10
1.2	**Замын барилга угсралтын ажил**	**27.3**	**2026.02.01**	**2028.05.10**
1.2.1	Нүүлгэн шилжүүлэлт, бэлтгэл ажил /ажиллах хүчин, машин механизм, кемп/	2	2026.02.01	2026.03.31
1.2.2	Газар шорооны ажил (далан, ухмал, суурь)	19	2026.03.10	2027.10.10
1.2.3	Суваг шуудуун ажил	6	2027.04.01	2027.09.30
1.2.4	Төмөр бетон гүүрийн ажил	25.3	2026.03.20	2028.05.01
1.2.5	Хоолойн ажил	15	2026.07.01	2027.09.30
1.2.6	Туннелийн ажил	25.3	2025.03.20	2028.05.01
1.2.7	Хучилтын ажил	9.6	2027.07.01	2028.04.20
1.2.8	Замын тэмдэг, тэмдэглэгээ, тоноглолын ажил	8	2027.09.01	2028.05.01
1.2.9	**Авто замын зорчих хэсгийг хөдөлгөөнд нээх**	**0.6**	**2028.04.20**	**2028.05.10**
1.3	**Тохижилт, тоноглолын ажил**	**9**	**2028.02.01**	**2028.11.01**
1.3.1	Хиймэл байгууламж, тоноглолын ажил	8	2028.02.01	2028.10.01
1.3.2	Тохижилтийн ажил	5	2028.05.01	2028.10.01
1.4	**Мэдээлэл, холбоо, программ хангамж**	**17**	**2027.05.01**	**2028.10.01**
1.4.1	Холбооны сувагчлал, кабель шилжүүлэх шинээр барих, камержуулалт, тоног төхөөрөмж, программ хангамж	17	2027.05.01	2028.11.01
1.5	**Шугам сүлжээ, эрчим хүчний ажил**	**28**	**2026.06.01**	**2028.10.01**
1.5.1	Авто замын гэрэлтүүлэг	9	2027.08.01	2028.05.01
1.5.2	Авто замын трассад орсон ЦШС-г хамгаалах, шилжүүлэх, дэд станц шилжүүлэх, шинээр барих	23	2026.06.01	2028.05.01
1.5.3	Бусад инженерийн шугам сүлжээний байгууламжийн барилга угсралтын ажил	26	2026.08.01	2028.10.01
1.6	**Хүлээлгэн өгөх, туршилт, илэрсэн гэмтэл, дутагдал засварлах**	**2**	**2028.09.10**	**2028.11.10**
2	**Бусад**	**84**	**2025.11.10**	**2032.11.10**
2.1	**Газар чөлөөлөлт**	**18.6**	**2025.11.10**	**2026.05.30**
2.2	**Худалдан авалт**	**24.0**	**2026.01.01**	**2028.01.01**
2.3	**Зүгшрүүлэх, тохируулах**	**12.0**	**2028.11.10**	**2029.11.10**
2.4	**Чанарын доголдол арилгах**	**36.0**	**2029.11.10**	**2032.11.10**

**ГН*-ийн 8 дугаар зүйлд заасны дагуу ажил эхлэх, саатах, түр зогсох хугацаанд өөрчлөлт орсон, эсхүл ТЭЗҮ /Захиалагч/, зураг төслийн нэмэлт өөрчлөлт /Гүйцэтгэгч/-ийн улмаас Гэрээний

хавсралт 2-т заасан ажлын хамрах хүрээнд нэмэлт, өөрчлөлт орсон бол энэхүү хуваарьт өөрчлөлт оруулах үндэслэл болно.
**Зураг төслийг хэсэгчилсэн байдлаар батлуулж, магадлуулж ажиллана.
***Нүүлгэн шилжүүлэлт гэж Гүйцэтгэгчийн ажиллах хүчин, машин механизм, тоног төхөөрөмжийг төслийн талбайд шилжүүлэх ажиллаар ойлгоно.
****Газар чөлөөлөлтийг төслийн барилга угсралтын үе шаттай зэрэгцүүлэн гүйцэтгэн ажиллана.

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ 5-Д ЗААСАН БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ	ГҮЙЦЭТГЭГЧ
“.....”-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:	“.....” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ДАРГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХАВСРАЛТ 6

ДОТООДЫН НӨӨЦ АШИГЛАХ ШААРДЛАГА

“Нэгдүгээр тойрог зам” төслийн зураг төсөл, худалдан авалт, зам, замын байгууламжийн барилга угсралтын ажил, санхүүжилт (EPC+F) гүйцэтгэх Гүйцэтгэгч нь Монгол улсын дотоодын аж ахуй нэгж, иргэн эсхүл/болон хуулийн этгээд, бараа материал, ажил, үйлчилгээ, үйлдвэрлэл, ажиллах хүчийг дэмжиж, дараах оролцоог хангуулж ажиллана.

1. ШААРДЛАГА

1.1. Гүйцэтгэгч нь Гэрээний нийт үнийн дүнгийн 20%-иас багагүй үнийн дүн бүхий бараа, ажил, үйлчилгээг Монгол улсын дотоодын аж ахуй нэгж, үйлдвэрлэгч, иргэн эсхүл/болон хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ. Ингэхдээ Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтарч болно. (*Бараа, ажил, үйлчилгээг гэж “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуульд зааснаар ойлгоно.*)

1.2. Монгол улсын дотоодын аж ахуй нэгж, үйлдвэрлэгч, хуулийн этгээд гэдэгт 51%-иас дээш эзэмшигч нь Монгол улсын иргэн байх аливаа хуулийн этгээдийг хэлнэ.

1.3. Гэрээний хүрээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний талаар орон нутгийн иргэн, хуулийн этгээдэд тогтмол мэдээлнэ.

1.4. Гүйцэтгэгч нь уг төсөлд ажиллах хүний нөөц, машин механизм, худалдан авах бараа материал, ажил үйлчилгээ, тээвэр логистикийг доор заасан хувь хэмжээнээс багагүй хувийг Монгол улсын дотоодын зах зээлээс заавал авч ажиллана. Үүнд:

Хүснэгт 1. Монгол улсын дотоодын зах зээлээс авах хувь, хэмжээ

Д/д	**Нэр**	**Хувь, хэмжээ**
1	Ажиллах хүч (удирдлага, мэргэжилтэн инженер техникийн ажилтан, бусад ажилтан)	20%-иас багагүй
2	Үндсэн бараа, материал (цемент, арматур г.м.)	20%-иас багагүй
3	Машин, механизм	20%-иас багагүй
4	Ажил, үйлчилгээ (катеринг, цэвэрлэгээ, зөвлөх үйлчилгээ г.м.)	20%-иас багагүй
5	Тээвэр, логистик	20%-иас багагүй

2. ТОДОРХОЙЛОЛТ

2.1. АЖИЛЛАХ ХҮЧ

Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагад нийцсэн, төсөл хэрэгжүүлэх туршлага бүхий мэргэжлийн багийг бүрдүүлнэ. Дотоодын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагатай хамтарч ажиллах бөгөөд шаардлагатай сургалтад хамруулан ажлын байраар хангаж ажиллана. Үүнд төслийн удирдлага, мэргэжилтэн,

инженер техникийн ажилтан, холбогдох захиргааны болон бусад ажилтнууд хамаарна.

2.2. ҮНДСЭН БАРАА, МАТЕРИАЛ

Гүйцэтгэгч нь чанар, стандарт, Захиалагчийн шаардлагад нийцсэн бараа, материалыг төсөлд ашиглана. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоол “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт”-д дурдсан үндсэн бараа, материалыг дотоодын зах зээлээс Гүйцэтгэгч нь худалдан авна.

2.3. МАШИН МЕХАНИЗМ

Гүйцэтгэгч нь төслийн бүтээн байгуулалтын ажилд шаардагдах машин, механизмын хүрэлцээ, бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг бүрэн хангуулж, дотоодын аж ахуй нэгж, иргэн эсхүл/болон хуулийн этгээдийг оролцуулна.

2.4. АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

Гүйцэтгэгч нь төслийн барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг барих, засварлах, өргөтгөх, буулгах, шинэчлэх, хайгуул судалгаа хийх болон тэдгээрт холбогдох тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, турших, тохируулах ажил, үйлчилгээнд мэргэжлийн болон зөвшөөрөл бүхий дотоодын аж ахуйн нэгж, иргэн эсхүл/болон хуулийн этгээдийг оролцуулна.

2.5. ТЭЭВЭР, ЛОГИСТИК

Гүйцэтгэгч нь төсөл, түүнд шаардагдах бараа материал, тоног төхөөрөмж, машин механизм зэрэг бүтээгдэхүүний тээвэр болон логистикийн бэлэн, найдвартай, бүрэн бүтэн байдлыг хангуулж, дотоодын аж ахуй нэгж, иргэн эсхүл/болон хуулийн этгээдийг оролцуулна.

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ 6-Д ЗААСАН БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ	ГҮЙЦЭТГЭГЧ
“.....”-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:	“.....” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ДАРГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ